

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/32/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Эвиденсе аудит ХХК-ийн захирал: С.Бадамгарав Утас: 99057121 Цахим хаяг: info@evidenceaudit.mn Аудитын менежер: Т.Болортуяа Утас: 99017537 Цахим хаяг: Bolortuya@evidenceaudit.mn Ахлах аудитор: Д.Мөнхжаргал Утас: 70007121 Цахим хаяг: Munkhjargal.evidence@gmail.com Аудиторын туслах: Э.Билгүүн Утас: 95047121 Цахим хаяг: Bilguun@evidenceaudit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024, 03.15 № 638
танай _____-ны № _____-т

УЛААНБААТАР ЗАМ ЗАСВАР
АРЧЛАЛТЫН ГАЗАР
ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА Б.ГАЛХҮҮ ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Улаанбаатар зам засвар арчлалтын газар ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Баянзүрх дүүргийн гол болон туслах гудамж замуудад нийт 1,700 байршил буюу 47 гудамжинд 18,180 м² нүхэн эвдрэл, 96,000 м² гэр хорооллын шороог хусаж тэгшлэх, нягтруулах ажил, 2,200м³ авто замын далан хөвөөг засварлах ажил, 766у/м авто замын хашлага засварлах, 77м² чулуун зам засварлах, гүнтийн давааны чиглэлийн авто замын арчлалтын ажлын хүрээнд 47 байршилд 302 м² нөхөөс, асфальт бетон хучилт 7800 м², далан хөвөө дүүргэлт 2400 у/м, нийт 220,585у/м заадасны ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй, нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 зорилтын хүрээнд 36 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 96.9 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,855,607,361.26	3,699,938,373.98
1.1.2	Дансны авлага	1,740,772,677.09	4,079,872,012.81
1.1.3	Татвар,НДШ-ийн авлага	226,610.33	5,000,182.76
1.1.4	Бусад авлага	2,804,524,434.29	2,630,002,891.00
1.1.6	Бараа материал	2,225,132,585.58	2,635,185,066.01
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	4,814,791,591.18	0.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	13,576,365.98	14,474,973.67
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	15,454,631,625.71	13,064,473,500.23
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,302,458,354.68	4,037,504,520.95
1.2.2	Биет бус хөрөнгө	205,666.25	32,739.05
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,302,664,020.93	4,037,537,260.00
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	19,757,295,646.64	17,102,010,760.23
2.1.1.1	Дансны өглөг	558,766,434.38	1,015,071,643.18
2.1.1.3	Татварын өр	3,377,438,060.29	3,871,811,268.61
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	5,491,792,776.48	944,924,832.79
2.1.1.9	Нөөц /өртөлбөр/	1,166,522,888.38	2,161,051,129.48
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	6,028,592.10	5,553,992.10
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	10,600,548,751.63	7,998,412,866.16
2.2	Өр төлбөрийн нийт дүн	10,600,548,751.63	7,998,412,866.16
2.3.1	Төрийн өмч	7,859,113,826.92	7,765,127,992.86
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,167,698,193.21	1,167,698,193.21
2.3.9	Хуримтлагдсан ашиг	129,934,874.88	170,771,708.00
2.3.11	Эздийн өмчийн дүн	9,156,746,895.01	9,103,597,894.07
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	19,757,295,646.64	17,102,010,760.23

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (цэвэр)	18,101,635,805.10	43,162,619,525.46
2	Борлуулалтын өртөг	17,280,427,251.44	42,062,391,424.73
3	Нийт ашиг (алдагдал)	821,208,553.66	1,100,228,100.73
4	Хүүгийн орлого	0.00	34,953,948.09
5	Бусад орлого	389,258,377.75	378,197,121.64
6	Ерөнхий ба удирдлагын зардал	1,096,448,961.84	1,391,843,258.75
7	Санхүүгийн зардал	0.00	3,495,926.90
8	Бусад зардал	39,558,344.23	70,697,597.00
9	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-29,667,831.04	0.00
10	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	44,791,794.30	47,342,387.81
11	Орлогын татварын зардал	6,707,959.43	6,505,554.69
12	Татварын дараах ашиг (алдагдал)	38,083,834.87	40,836,833.12
13	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	38,083,834.87	40,836,833.12

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,680,713,826.92	811,472,120.21	97,757,730.01	7,589,943,677.14
2	Залруулсан үлдэгдэл	6,680,713,826.92	811,472,120.21	97,757,730.01	7,589,943,677.14
3	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		356,226,073.00		356,226,073.00
4	Өмчид гаргасан өөрчлөлт	1,178,400,000.00	-	-	1,178,400,000.00
5	Зарласан ногдол ашиг	-	-	(5,906,690.00)	(5,906,690.00)
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	38,083,834.87	38,083,834.87
7	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,859,113,826.92	1,167,698,193.21	129,934,874.88	9,156,746,895.01
8	Залруулсан үлдэгдэл	7,859,113,826.92	1,167,698,193.21	129,934,874.88	9,156,746,895.01
9	Өмчид гаргасан өөрчлөлт	(93,985,834.06)	-	-	(93,985,834.06)
10	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	40,836,833.12	40,836,833.12
11	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	7,765,127,992.86	1,167,698,193.21	170,771,708.00	9,103,597,894.07

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	22,227,859,550.70	45,873,371,370.89
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	22,223,522,380.78	45,793,441,917.34
1.1.6	Бусад мөнгөн орлого	4,337,169.92	79,929,453.55
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	19,302,567,366.74	45,604,467,770.90
1.2.1	Ажилагсад төлсөн	1,890,531,259.82	2,354,746,698.82
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	622,709,584.58	770,236,152.48
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	14,744,500,909.33	38,864,867,785.13
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	78,556,386.16	98,118,253.37
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,408,706,500.00	2,146,209,934.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	242,243,133.44	664,376,925.23
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	11,213,910.00	26,476,234.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	304,105,683.41	679,435,787.87
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,925,292,183.96	268,903,599.99
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	86,646,318.19	424,572,587.27
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	86,646,318.19	424,572,587.27
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-86,646,318.19	-424,572,587.27
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00

3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,906,690.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	5,906,690.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-5,906,690.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,832,739,175.77	-155,668,987.28
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,022,868,185.49	3,855,607,361.26
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,855,607,361.26	3,699,938,373.98

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Авто зам, замын байгууламж барих, засвар, арчлалтын газар	12,861,423,200.00	9,475,974,000.00	36,382,872,300.00	(26,906,898,300.00)	383.95
2	Авто замын тэмдэг тэмдэглэгээний ажил	1,486,360,400.00	1,700,000,000.00	3,116,895,200.00	(1,416,895,200.00)	183.35
3	Хайс, хашлаганы засвар арчлалт	222,208,600.00	150,000,000.00	2,197,638,400.00	(2,047,638,400.00)	1,465.09
4	Гүүрийн байгууламж, нүхэн гарцны ашиглалт үйлчилгээ	474,418,700.00	500,000,000.00	449,095,400.00	50,904,600.00	89.82
5	Асфальт, бетон хольц үйлдвэрлэлийн орлого	1,289,664,700.00	700,000,000.00	766,690,200.00	(66,690,200.00)	109.53
6	Төлбөртэй авто зогсоолын орлого	202,860,000.00	205,344,000.00	326,956,500.00	(121,612,500.00)	159.22
7	Бусад орлого	186,398,400.00	300,000,000.00	335,622,600.00	(35,622,600.00)	111.87
Нийт орлогын дүн		16,723,334,000.00	13,031,318,000.00	43,575,770,600.00	(30,544,452,600.00)	
1	Цалин	2,222,251,200.00	2,852,015,200.00	2,806,524,600.00	45,490,600.00	98.40
2	Хоол унааны хөнгөлөлтийн зардал	177,101,400.00	331,056,000.00	197,744,800.00	133,311,200.00	59.73
3	Нийгмийн даатгалын шимтгэл	344,775,200.00	461,545,300.00	770,396,600.00	(308,851,300.00)	166.92
4	Удирдах зөвлөлийн зардал	25,200,000.00	45,342,000.00	33,000,000.00	12,342,000.00	72.78
5	Сэлбэг хэрэгсэл	209,404,000.00	191,492,700.00	351,572,500.00	(160,079,800.00)	183.60
6	Ашиглалтын зардал	97,099,200.00	89,400,000.00	80,135,907.38	9,264,092.62	89.64
7	Түрээсийн зардал	503,718,600.00	100,000,000.00	413,768,100.00	(313,768,100.00)	413.77
8	Тос, тосолгооны зардал	50,389,900.00	60,839,000.00	84,436,800.00	(23,597,800.00)	138.79
9	Хөдөлмөр хамгааллын зардал	42,527,400.00	51,010,000.00	41,987,600.00	9,022,400.00	82.31
10	Түүхий эд материал	5,337,753,500.00	5,222,420,000.00	16,719,203,700.00	(11,496,783,700.00)	320.14
11	Урсгал засварын зардал	4,012,800.00	33,000,000.00		33,000,000.00	-
12	Шатахуун	1,080,225,000.00	1,492,405,000.00	2,146,209,900.00	(653,804,900.00)	143.81
13	Шуудан холбоо, бичиг хэрэгсэл	30,818,700.00	26,413,000.00	53,428,500.00	(27,015,500.00)	202.28
14	Сургалт	3,254,500.00	9,060,000.00	8,253,700.00	806,300.00	91.10
15	Үндсэн хөрөнгийн элэгдэл	534,704,800.00	539,286,000.00	553,533,400.00	(14,247,400.00)	102.64
16	Албан журмын даатгал, татвар	11,213,900.00	33,000,000.00	26,156,200.00	6,843,800.00	79.26
17	Хангамж материал	31,620,800.00	46,118,800.00	43,841,100.00	2,277,700.00	95.06

18	Нийгмийн арга хэмжээний зардал	39,971,600.00	40,033,000.00	39,537,800.00	495,200.00	98.76
19	Ахмадын сан		28,520,200.00	11,560,000.00	16,960,200.00	40.53
20	Төлбөрт үйлчилгээний зардал	121,700,000.00	123,206,400.00	123,206,400.00	-	100.00
21	Он дамнасан ажлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	5,804,967,300.00	600,000,000.00	2,500,000,000.00	(1,900,000,000.00)	416.67
22	2023 оны гэрээт ажлын Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал		500,000,000.00	16,427,828,600.00	(15,927,828,600.00)	3,285.57
23	Гамшгийн үеийн менежментийн зардал	5,367,400.00	24,115,000.00	16,102,000.00	8,013,000.00	66.77
24	Үйл ажиллагааны бус зардал	21,086,700.00	15,000,000.00	80,000,000.00	(65,000,000.00)	533.33
Нийт зардлын дүн		16,699,163,900.00	12,915,277,600.00	43,528,428,207.38	(30,613,150,607.38)	
25	Татварын өмнөх ашиг	24,170,100.00	116,040,400.00	47,342,392.62		
26	Орлогын татвар	5,318,800.00	11,604,040.00	6,505,600.00		
27	Цэвэр ашиг алдагдал	18,851,300.00	104,436,360.00	40,836,792.62	63,599.6	

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 1 зөрчил¹ илэрсэнд зөвлөмж өгсөн.

5.3 Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт-1:

Байгууллагын мөрдөж байгаа “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь бүртгэлийн үйл ажиллагаанд нийцээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуй нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйлийн 20.2.2 “аж ахуй нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хууль, стандарт, дүрэм, журам, зааварт өөрчлөлт орсон тухай бүрд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох өөрчлөлтийг оруулан баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллах.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо
НББ-ийн бодлогын баримт бичиг нь шаардлага хангахгүй байна.	1	-					1	-					
Дүн	1	-					1	-					

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо		Санал дүгнэлтийн хэлбэр
		А	У	

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалт тай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс тагталзсан
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр		1			1			
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ		1			1			